



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоол, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 7.3.2.2 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтын тооцоог 2020 оны хагас жилийн байдлаар гаргаж, үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болгосугай.

2. Хүчингүй болгох хэвлэмэл хуудсыг хавсралтаар баталсугай.

3. Хүчингүй болгосон хэвлэмэл хуудасны тооцоог албан хаагчдаар төлүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Хэвлэмэл хуудасны ашиглалтыг сайжруулж, үргүй зардал гаргахгүй байх, стандартын шаардлага хангасан баримт бичиг боловсруулж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын дарга Н.Пүрэвсүрэнд даалгасугай.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ

